



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 11 сарын 11 өдөр

Дугаар 485

Улаанбаатар хот

Зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрмийн 6.6.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дорноговь аймгийн Замын-Үүд суманд Коронавирусын халдварын тоо эрчимтэй нэмэгдэж, эрсдэлийн үнэлгээгээр (маш өндөр) гэж үнэлэгдсэнийг харгалзан үзэж, Дорноговь аймгийн Замын-Үүд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Н.Алдарбаяраас ирүүлсэн хүсэлтийн дагуу нийгмийн хариуцлагын хүрээнд сумын Засаг даргын Тамгын газарт хамгаалах хэрэгсэл, түргэвчилсэн оношлуур, эмийн багц, хүчилтөрөгчийн аппарат худалдан авахад шаардагдах 100,000,000 (нэг зуун сая) төгрөгийн хөрөнгийг “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” төрийн өмчит үйлдвэрийн газрын цэвэр ашгийн чөлөөт үлдэгдлээс санхүүжүүлэхийг захирал Г.Гансүхэд зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132001425